



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 12 сарын 28 өдөр

Дугаар А/410

Улаанбаатар хот

МУИС-ийн магистр, докторын хөтөлбөрт  
суралцагч элсүүлэх журам батлах тухай

Монгол Улсын Дээд Боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, 12.1.6, Монгол Улсын Их Сургуулийн дүрмийн 4.3.8.4, 4.3.8.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. МУИС-ийн Захиргааны зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу “МУИС-ийн магистр, докторын хөтөлбөрт суралцагч элсүүлэх журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.


2. Энэхүү журмыг 2017-2018 оны хичээлийн жилийн хаврын улирлын элсэлтээс эхлэн мөрдөж, хэрэгжилтэнд нь хяналт тавьж ажиллахыг Сургалт, оюутан хариуцсан дэд захирал /Б.Очирхуяг/, Сургалтын нэгдсэн газрын дарга /Л.Одонтуяа/, Элсэлтийн албаны дарга /М.Эрдэнэчимэг/, Мэдээллийн технологийн газрын дарга /А.Баатарбилэг/, Бүрэлдэхүүн сургуулийн захирал /Б.Баяртогтох, Ж.Эрдэнэбулган, Ч.Энхбаяр, Н.Баатарбилэг, С.Баттулга, П.Оюунбилэг, Т.Энх-Амгалан/ нарт үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсан холбогдуулан МУИС-ийн захирлын 2015 оны 07 дугаар сарын 10-ны өдрийн А/220 тоот тушаалаар батлагдсан “МУИС-ийн магистр, докторын хөтөлбөрт суралцагч элсүүлэх журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРЛЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Я.ТӨМӨРБААТАР



Захирлын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 4/410 дугаар тушаалын хавсралт

## МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН МАГИСТР, ДОКТОРЫН ХӨТӨЛБӨРТ СУРАЛЦАГЧ ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

### НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. МУИС-ийн магистр, докторын хөтөлбөрт суралцагч элсүүлэх элсэлтийн үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. МУИС-ийн магистр, докторын хөтөлбөрт суралцагч элсүүлэхэд БСШУ-ны сайдын 2014 оны А/370 дугаар тушаалаар баталсан “Магистр докторын сургалт эрхлэхэд баримтлах нийтлэг журам”, “МУИС-ийн Сургалтын журам” болон энэхүү журмыг (цаашид “журам” гэнэ) мөрдөнө.

1.3. МУИС-д элсэхийг хүссэн гадаадын харьяат иргэдийн асуудлыг тусгай журмаар зохицуулна.

1.4. МУИС-ийн магистр, докторын хөтөлбөрт элсэхээр хүсэлт гаргагчийг “бүртгүүлэгч”, элсэлтийн шалгалт өгч элсэх болзол хангасан бүртгүүлэгчийг “элсэгч”, элсэлтийн цахим бүртгэлийн мэдээллийн системийг “бүртгэлийн нэгдсэн систем”, элсэлтийн үйл ажиллагааг нэгдсэн байдлаар зохион байгуулахаар томилогдсон комиссыг “элсэлтийн комисс”, элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахад оролцох ажилтныг “комиссын гишүүн” гэнэ.

1.5. Элсэлтийн комиссын даргаар Сургалт, оюутан хариуцсан дэд захирал, нарийн бичгийн даргаар Сургалтын нэгдсэн газрын Элсэлтийн албаны дарга, гишүүдээр Сургалтын нэгдсэн газрын дарга, Ахисан түвшний сургуулийн бодлогын газрын дарга, Мэдээллийн технологийн газрын дарга, Бүрэлдэхүүн сургуулийн захирал, Тэнхимийн эрхлэгч, багш, Элсэлтийн албаны мэргэжилтэн нарыг тус тус МУИС-ийн захирлын тушаалаар томилно.

1.6. Эзэмшсэн бакалавр, магистрын мэргэжил нь өөр чиглэл (эрх зүйн хөтөлбөрөөс бусад)-тэй элсэгчийг нөхөн судлах нөхцөлтэйгөөр бэлтгэл магистр, докторын хөтөлбөрт элсүүлнэ. Магистр, докторын бэлтгэл хөтөлбөрт элсэгч нь элссэн хөтөлбөрийнхөө харгалзах түвшний мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлээс 15 хүртэл багц цагийн хичээлийг судална.

1.7. Магистр, докторын элсэлт авах хөтөлбөр, элсэлтийн бүртгэл, элсэлтийн шалгалтын хуваарь зэрэг элсэлттэй холбоотой бусад мэдээллийг Элсэлтийн алба элсэлт авах бүрт олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, <http://burtgel.num.edu.mn>, <http://graduate.num.edu.mn> цахим хуудсуудад байрлуулна.

1.8. Энэхүү журмаар зохицуулаагүй асуудлыг Элсэлтийн комисс шийдвэрлэнэ.

1.9. Энэхүү журмыг МУИС-ийн салбар сургууль (Завхан, Эрдэнэт)-д нэгэн адил дагаж мөрдөнө.

### ХОЁР. БҮРТГҮҮЛЭГЧДЭД ТАВИХ ШААРДЛАГА

2.1. Магистрын хөтөлбөрт бакалаврын зэрэгтэй, докторын хөтөлбөрт магистрын зэрэгтэй бүртгүүлэгчийг элсүүлнэ.

2.2. Хууль зүйн сургуулийн магистрын хөтөлбөрт эрхзүйн бакалаврын, докторын хөтөлбөрт эрхзүйн магистрын зэрэгтэй бүртгүүлэгчийг элсүүлнэ.

### ГУРАВ. ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛ

3.1. Магистр, докторын хөтөлбөрийн элсэлтийн бүртгэлийг цахим хэлбэрээр явуулах бөгөөд элсэлт авах хөтөлбөр, хэлбэр (өдөр, эчнээ, бэлтгэл), хяналтын тоог бүртгэлийн нэгдсэн системд оруулж, намрын улиралд 07 дугаар сарын 15-наас 09 дүгээр сарын 10-ны хооронд, хаврын улиралд 11 дүгээр сарын 10-наас 01 дүгээр сарын 10-ны хооронд <http://burtgel.num.edu.mn> хаягаар явуулна.

3.2. Эрэлт ихтэй зарим хөтөлбөрийн хяналтын тоог бүрэлдэхүүн сургуулийн саналыг үндэслэн МУИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулж, бүртгэлийн нэгдсэн системд оруулна.

3.3. Элсэлтийн бүртгэл нь дараах үе шаттай явагдана. Үүнд:

3.3.1. Бүртгүүлэгч нь МУИС-ийн бүртгэлийн нэгдсэн системд шаардлагатай мэдээллийг оруулж элсэх хүсэлтээ гаргана.

3.3.2. Бүртгүүлэхдээ бүртгэлийн нэгдсэн систем дэх анкетыг бөглөж, дараах бичиг баримтыг цахим хэлбэрээр хавсаргана. Үүнд:

-Иргэний үнэмлэх эсвэл түүнтэй адилтгах баримт бичгийн хуулбар (төрсний гэрчилгээ, гадаад паспорт);

-Эзэмшсэн боловсролын диплом, түүний хавсралтын хуулбар;

-Цээж зураг

3.3.3. Бүртгүүлэх боломжтой хөтөлбөрийн жагсаалтыг системээс харах бөгөөд бүртгүүлэгч элсэхийг хүссэн хөтөлбөрөө сонгоно.

3.3.4. Элсэхийг хүссэн хөтөлбөрийг сонгосон үед төлбөл зохих бүртгэлийн хураамжийн хэмжээ гарах бөгөөд хураамжийг цахим хэлбэрээр хийснээр бүртгэл баталгаажна.

3.4. Тус журмын 3.3.2-т заасан бичиг баримт гадаад хэл дээр бол албан ёсны орчуулга хийлгэн, нотариатаар батлуулсан байна.

3.5. Бүртгүүлэгч нь хэдэн ч хөтөлбөрт элсэн суралцах хүсэлт гаргаж болох ба бүртгүүлсэн хөтөлбөрийн тоогоор бүртгэлийн хураамжийг цахимаар төлнө.

3.6. Бүртгүүлэгч нь бүртгэлийн нэгдсэн системд өөрийн гар утасны дугаар, цахим шуудангийн хаягийг заавал бүртгүүлэх бөгөөд ~~эдгээр мэдээллийн үнэн зөв байдлыг бүртгүүлэгч өөрөө хариуцна.~~ Бичиг баримтыг дутуу буюу буруу оруулсан тохиолдолд шалгалтанд оруулахгүй байх үндэслэл болно.

3.7. Бүртгүүлэгч хэдэн ч сургууль, салбар, хөтөлбөрт бүртгүүлж болох боловч элсэлтийн шалгалтанд тэнцсэн өөрийн сонирхсон зөвхөн нэг хөтөлбөрт элсэх эрх авна.

#### ДӨРӨВ. ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ

4.1. Бүртгүүлэгч бакалаврын зэргийн боловсролоо МУИС-д эзэмшиж 3.0-оос дээш голчтой төгссөн бол тухайн мэргэжлээрээ МУИС-ийн магистрын хөтөлбөрт шалгалтгүйгээр элсэнэ.

4.2. Уг журмын 4.1 дэх заалтын болзлыг хангаагүй бүртгүүлэгч нь элсэх мэргэжлийн чиглэлийн дагуу шалгалт өгнө. Шалгалтын зохион байгуулалтыг Элсэлтийн комисс хариуцан гүйцэтгэнэ. Шалгалтыг мэргэжлийн тэнхим үнэлж, үнэлгээг Элсэлтийн албанд ирүүлнэ.

4.3. Магистр, докторын бэлтгэл хөтөлбөрт бүртгүүлэгчээс мэргэжлийн тэнхимийн онцлогоос хамаарч шалгалт авна. Шалгалтыг хэрхэн зохион байгуулах, хөтөлбөрт ямар нөхцөлтэй элсүүлэн суралцуулахыг тухайн элсэгчийн мэргэжил, өмнө үзсэн хичээл зэргийг мэргэжлийн хөтөлбөр, тэнхимийн саналыг үндэслэн элсэлтийн комисс шийдвэрлэнэ.

4.4. Энэхүү журмын 1.6-д заасны дагуу магистр, докторын бэлтгэл хөтөлбөрт элсэн нөхөн судлах багц цагаа амжилттай гүйцээсэн суралцагч үндсэн магистр болон докторын хөтөлбөрт шалгалт өгч үргэлжлүүлэн суралцана.

4.5. Шалгалт дууссаны дараа Элсэлтийн алба шалгалтын дүнг нэгтгэн гаргаж, бүртгэлийн нэгдсэн системд оруулна.

4.6. Шалгалт авах өдөр, цаг, байр болон шалгалттай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг бүртгэлийн хугацаанд <http://burtgel.num.edu.mn> цахим хуудсанд байршуулна.

4.7. Шалгалтад авбал зохих нийт онооны 60-аас доошгүй хувийг авсан шалгуулагчдыг оноогоор нь жагсааж, онооны дарааллаар хяналтын тоонд багтаан элсүүлнэ.

4.8. Оноо тэнцсэн тохиолдолд өмнө эзэмшсэн боловсролын дипломын голч оноог харгалзана.

#### ТАВ. ЭЛСЭГЧИЙГ ШАЛГАРУУЛАХ БА МЭДЭГДЭХ

5.1. Бүртгүүлэгчдэд шалгалтын дүнг МУИС-ийн бүртгэлийн нэгдсэн системээр мэдэгдэнэ.

5.2. Бүртгүүлэгчдийг шалгалтын нийт онооны дарааллаар жагсаах ба элсэх болзол хангасан бүртгүүлэгчдийн бүртгэлийн дугаарыг Элсэлтийн албаны мэдээллийн самбар болон цахим хуудсаар албан ёсоор зарлана.

5.3. Шалгалтад тэнцсэн элсэгч заасан хугацаанд бүртгүүлэхээр ирэхдээ дараах материалыг бүрдүүлж битүүмжилсэн хавтсанд хийсэн байна. Үүнд:

- Иргэний үнэмлэх эсвэл түүнтэй адилтгах баримт бичиг (төрсний гэрчилгээ, гадаад паспорт), хуулбарын хамт;
- Өмнө нь эзэмшсэн боловсролын диплом, хавсралт (бакалавр болон магистрын диплом) хуулбарын хамт;
- Цээж зураг хоёр хувь, бүртгэлийн нэгдсэн системийн шаардлагад нийцсэн цээж зураг файл хэлбэрээр (сүүлийн гурван сард авахуулсан).

5.4. Бүртгэлийн мэдээллийг бичиг баримтын эх хувьтай нь шалгаж, Сургалтын нэгдсэн газрын тухайн сургуулийг хариуцсан бүртгэлийн мэргэжилтэнд бүртгүүлэн сургалтын мэдээллийн систем ашиглах эрхээ авна.

5.5. Хяналтын тоонд багтсан элсэгч нь энэхүү журмын 5.3-д заасны дагуу бүртгүүлээгүй бол элсэн суралцах эрхээсээ татгалзсан гэж үзэж тус журмын 4.7-д заасан шаардлагыг биелүүлсэн дараагийн хүнд эрхийг шилжүүлнэ.

#### ЗУРГАА. БУСАД

6.1. Бүртгүүлэгч бүртгүүлэхээс өмнө энэхүү журамтай танилцах үүрэгтэй.

6.2. Бүртгүүлэгчийг хүсэлт гаргасан хөтөлбөрөөс өөр хөтөлбөрт шилжүүлэн элсүүлэхгүй.

6.3. Бүртгүүлэгч системд бүртгүүлсэн боловч МУИС-ийн үйл ажиллагаанаас үл хамааран элсэлтийн шалгалтыг өгөөгүй бол бүртгэлийн хураамжийг буцааж олгохгүй.

6.4. Элсэх болзол хангасан боловч заасан хугацаанд ирж бүртгүүлээгүй /суралцах гэрээ байгуулаагүй/ хүнийг суралцахаас татгалзсанд тооцож элсэх эрхийг хүчингүйд тооцно.

6.5. Элсэлттэй холбоотой бичиг баримтыг хуурамчаар үйлдвэл МУИС-д элсүүлэхгүй бөгөөд хуурамч бичиг баримтаар элссэн нь тогтоогдсон тохиолдолд хасах буюу хуулийн байгууллагад мэдэгдэнэ.